



## УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

### ХХ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдааныг 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 15:00 цагт Төрийн ордон дахь “Чингис хаан танхим”-д 20 хувийн ирцтэй хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

#### ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Коронавируст халдвар /Ковид-19/ халдварын нөхцөл байдал, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

*Эрүүл мэндийн сайд,  
Улсын онцгой комиссын гишүүн С.Энхболд*

1. Вакцины дараах дархлаа тогтоцын судалгаа, үр дүн

*ХӨСҮТ-ийн захирал, Л.Баттөр,*

2. “Гадаад улсаас ирсэн хүнийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам”-ын нэмэлт өөрчлөлт оруулах төсөл,

*Шуурхай штабын дарга, хурандаа  
Ц.Ганзориг,*

3. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацааг сунгах, нэмэлт өөрчлөлтийн төсөл,

*Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга,  
дэд хурандаа Т.Баярхүү*

4. Бусад

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

*Нэг. Улсын онцгой комиссын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:*

1.1. Халдварын тархалт, үүссэн нөхцөл байдлын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд хэсэгчилсэн байдлаар хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох шийдвэрийг Улсын онцгой комисстой зөвшилцөн гаргах, гаргасан шийдвэрийн талаар иргэд, олон нийтэд шуурхай хүргэж ажиллах;

1.2. Хот хоорондын зорчигч тээврийн үйл ажиллагаа, түүгээр зорчих иргэдэд тавих хяналтыг чангатгах, шаардлагатай тохиолдолд тэдгээрт тавих тусгай шаардлага, нөхцлийг сайжруулах;

*Хоёр. Улсын онцгой комиссын гишүүн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Т.Гантулга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:*

2.1. Худалдаа, үйлчилгээ эрхлэгчид хууль, журамд заасан шаардлага, халдвар хамгааллын дэглэм мөрдөх чиглэлд тогтмол хяналт тавих, зөрчил гаргасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд хуульд заасан арга хэмжээ авч, халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах;

2.2. Монгол Улсын Засгийн газрын 118 дугаар тогтоол зөрчиж “Улбар шар түвшин”-д хязгаарласан үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хатуу хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоож, тусгай зөвшөөрлийг нь цуцлах хүртэл арга хэмжээг авч ажиллах;

*Гурав. Улсын онцгой комиссын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд нарт:*

3.1. Эм эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис, оношлуурын нөөцийг тогтмол бүрдүүлж, шаардлагатай санхүү төсөвт зохицуулалт хийх;

3.2. Вакцинжуулалтын дараах дархлаа тогтоцын судалгааны ажлыг өргөжүүлэх, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх;

3.3. Вакцинжуулалтын 3 дугаар тунг хийгдэх эсэх талаарх судалгааг эцэслэж, дүнг Улсын онцгой комисст танилцуулах;

3.4. Коронавируст халдвар /Ковид-19/-ын батлагдсан тохиолдлыг эрэмблэн ангилах үйл ажиллагаанд хяналт тавих, хариу арга хэмжээний багт мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөх ажлын хэсэг байгуулан ажиллуулах;

*Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт:*

4.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын батлагдсан тохиолдол, ойрын хавьтал болсон иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд боловсролын салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их

сургуулийн ахлах болон төгсөх дамжааны оюутнуудыг дайчлан ажиллуулах, тэдгээртэй холбогдон гарах цалин, урамшууллыг шийдвэрлэх;

*Тав. Улсын онцгой комиссын гишүүн Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэлтэй харилцах газрын дарга Ц.Ганзориг нарт:*

5.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын батлагдсан тохиолдолд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зохион байгуулалт, эрэмблэн ангилалт, шаардлагатай эмчилгээний талаарх зөвлөмж зөвөлгөө, мэдээ, мэдээллийг боломжит бүх сувгаар иргэд, олон нийтэд тогтмол хүргэх;

*Зургаа. Улсын онцгой комиссын гишүүн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт:*

6.1. Батлагдсан тохиолдол болон халдварын шинж тэмдэг илэрсэн иргэнд эрүүл мэндийн яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх, тандалт хариу арга хэмжээ зохион байгуулахаар дайчлагдан ажиллах автобус, шаардлагатай шатахууны зардлыг шийдвэрлэх;

6.2. Үйл ажиллагааг нь нээсэн худалдаа, үйлчилгээний салбаруудын цагийн хуваарьт хязгаарлалт, зохицуулалт хийж халдвар тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авч, хатуу хяналт тавьж ажиллах /хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрыг 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 7 хоногийн хугацаатай заалаар үйлчлэхийг хориглох, амралт, жуулчны баазын үйл ажиллагааг 6 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 7 хоногийн хугацаанд үйл ажиллагааг нь хязгаарлах/;

*Долоо. Улсын онцгой комиссын орлогч дарга, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Улсын онцгой комиссын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Дорноговь аймгийн Засаг дарга О.Батжаргал, Өмнөговь аймгийн Засаг Р.Сэддорж нарт:*

7.1. Өмнөговь болон Дорноговь аймаг руу зорчих иргэдийн хөдөлгөөнд 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 06:00 цагаас эхлэн 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд хязгаарлалт тогтоож, төрийн байгууллагын албан томилолтоор зорчих иргэдийн зөвшөөрлийг Улсын онцгой комиссын Шуурхай штабаас, бусад шаардлагаар зорчих иргэдийн зөвшөөрлийг ямар ч тохиолдолд коронавируст халдварын шинжилгээний сөрөг хариунд үндэслэн тухайн аймгийн Онцгой комиссоос олгох;

7.2. Экспортын үйл ажиллагааг эрчимжүүлэх удирдлага зохион байгуулалтаар хангах, шаардлагатай хязгаарлалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор Дорноговь, Өмнөговь аймгуудад Батлан хамгаалахын сайдаар ахлуулсан Шуурхай бүлэг томилж, ажиллуулах;

*Найм. Улсын онцгой комиссын гишүүн, ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга дэд хурандаа Т.Баярхүү нарт:*

8.1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацааг

сунгах, нэмэлт өөрчлөлтийн төсөлд яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулах;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, дэд хурандаа Т.Баярхүү, Шуурхай штабын дарга, хурандаа Ц.Ганзориг нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,  
ДЭД ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

